



БАЯНХОНГОР АЙМГИЙН
ЖИНСТ СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН
ХУРЛЫН ХУРАЛДААНЫ ТОГТООЛ

2020 оны 12 сарын 18 өдөр

Дугаар 2/14

Бодь

Сум хөгжүүлэх сангийн орлого, олгох зээлийн багц, үйл ажиллагааны зардал, олгох зээлийн дээд хэмжээ, төсөл сонгон шалгаруулах тов тогтоож батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.2, Засгийн газрын 2016 оны 153 дугаар тогтоолоор батлагдсан "Сум хөгжүүлэх сангийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах, тайлагнах, хяналт тавих журам"-ын 1.8, 1.11, 3.3.1, 3.5.7 дахь заалтуудыг тус тус үндэслэн сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит 2 дугаар Хуралдаанаас ТОГТООХ нь:

1. 2020 оны сангийн эцсийн үлдэгдэл 54.990.000 /Тавин дөрвөн сая есөн зуун ерэн мянган/ төгрөгийг тодотгож, 2021 онд сум хөгжүүлэх санд зээлийн эргэн төлөлт, зээлийн хүүгээс төвлөрөх 89.600.000 /Наян есөн сая зургаан зуун мянган/ төгрөг, тус сангаас 2021 онд зээл олголтонд 148.400.00 /Нэг зуун дөчин найман сая дөрвөн зуун мянган/ төгрөгийг 1 дүгээр хавсралтаар, өмнөх онуудад сангаас олгосон зээлийн жилийн хүүгийн орлогын 50 хувь буюу 2.100.000 /Хоёр сая нэг зуун мянган/ төгрөгийг үйл ажиллагааны зардалд зарцуулахыг зөвшөөрч 2 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Тухайн жилд нэг төсөлд олгох зээлийн дээд хэмжээг иргэнд 30.000.000 /Гучин сая/ төгрөгөөр, аж ахуй нэгжид 50.000.000 /Тавин сая/төгрөгөөр тус тус баталсугай.


3. Сум хөгжүүлэх сангийн төсөл сонгон шалгаруулах хурлын товыг 2021 оны сар бүрийн 10-ны өдрөөр товлосугай.

1617093

4. Сангийн үйл ажиллагааг холбогдох хууль журмын дагуу явуулж, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд тайлагнаж ажиллахыг сумын Засаг дарга /Р.Батжаргал/-д үүрэг болгосугай.

ДАРГА  Д.АМАР-АМГАЛАН





Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны
12 дугаар сарын 18-ны өдрийн 2 дугаар хуралдааны
2/14 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралт

СУМ ХӨГЖҮҮЛЭХ САНГИЙН 2021 ОНЫ ОРЛОГО,
ЗАРЛАГА, ЗЭЭЛИЙН БАГЦ

Үзүүлэлт	Орлого	Зарлага
Сангийн 2020 оны эцсийн үлдэгдэл	5499000	
2021 онд зээл, хүүгээс орох орлого	89,600,000	
Нийт орлого	148,400,000	
2021 онд олгох зээл /зарлага/		148,400,000

оОо



Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны
12 дугаар сарын 18-ны өдрийн 2 дугаар хуралдааны
2/14 дүгээр тогтоолын 2 дугаар хавсралт



**2021 ОНД СУМ ХӨГЖҮҮЛЭХ САНГИЙН ТӨСӨЛ СОНГОН ШАЛГАРУУЛАХ
ЗӨВЛӨЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНД ЗАРЦУУЛАХ ТӨСӨВ**

д/д	Зориулалт		Тоо хэмжээ	Нэгж үнэ	Мөнгөн дүн
1	Хяналт шалгалтын ажил, сангийн бүрдүүлэлт, бичиг хэрэг 20%	Бичиг хэргийн зардал			330,000
2		Хэвлэгчийн хор	2 ш	70000	140,000
3		Шатахуун			400,000
4		Санхүүгийн тайлан гаргах, зээлийн эргэн төлөлтөд хяналт хийх, зээлдэгчдийн материалыг шүүхэд баримт бүрдүүлэх хүргэх томилолт /жилд/	12 хоног	50000	600,000
5		Сургалт 30%	Сургалт		
НИЙТ ДҮН					2,100,000

2020 онд зээлийн хүү нийт- 4200000 төгрөг төвлөрнө. Хүүний 50%- 2100000 төгрөг

оОо

